

Өрмийн алхны тос (Биологийн тос)

ТОДОРХОЙЛОЛТ

Black Diamond компанийн Өрмийн алхны тос бол доор цохилтот алхны бүрэн тосолгоонд зориулагдсан байгальд ээлтэй, аюулгүй өрмийн алхны тос юм. Энэхүү биологийн идэвхит бөгөөд ургамлын тосноос (ногооны хаягдал) гаргаж авсан тосолгооны материал нь зунгаг чанар багатай, туйлт чанар өндөр учир алхны эд анги, үе, хэсэг бүрийг бүрхэн хамгаална. Энэхүү Өрмийн алхны тос таны доор цохилтот алхны эдэлгээг уртасгаж, гүйцэтгэлийг сайжруулах болно.

АЖИЛЛАГАА / ҮР ДҮН

Black Diamond компанийн Өрмийн алхны тос бол цохилтот алхны эдэлгээг уртасгаж, гүйцэтгэлийг сайжруулагч өндөр түвшний, байгальд ээлтэй, биологийн идэвхит тосолгооны материал юм.

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

- Ургамлын тосноос гаргаж авсан
- Байгальд ээлтэй
- Гадаргын ус бохирдуулахгүй
- Хог хаягдал болгоход хялбар
- Хаягдал багатай
- Нүүрстөрөгчийн ялгарал бага

ЭДИЙН ЗАСГИЙН ҮР НӨЛӨӨ

- Химийн тостой харьцуулахад зарцуулалт бага
- Алхны ажиллагаа, эдэлгээг уртасгана
- Халалт үүсч, алхны гол элэгдэхээс хамгаална

ХЭРЭГЛЭЭ

Бид танд нэгэн жигд тосолгооны арга ашиглан алхыг тогтмол тослохыг зөвлөж байна. Туршилт судалгаанаас үзэхэд шаардагдах хэрэглээ нь уламжлалт өрмийн алхны тосны 70%-тай тэнцэхүйц хэмжээтэй гарсан.



БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ӨРМИЙН АЛХНЫ ТОС ХЭРЭГЛЭХИЙН АШИГ ТУС



Байгаль орчинд аюулгүй – Black Diamond-ын байгальд ээлтэй өрмийн алхны тос бол биологийн задралд орох чадвартай биологийн идэвхит тос юм. Найрлаганд нь нефтийн түүхий эд, хольц ороогүй учраас байгаль орчинд аюулгүй.



Ажилчдад аюулгүй – Уг биологийн идэвхит тос нь түргэн ууршдаг органик нэгдэл (ТУОН) багатай учир хорт хий ялгарах нь бага, түүнчлэн орчны агаар нөлөө үзүүлэхгүй тул ажилтны нүд болон арьс загатнуулж харшлахгүй.



Нэвтрэлтийн хурд өндөр – Өрмийн алхны тос зунгаг чанар багатай учраас алхны доторх бүх хөдөлгөөнт хэсгүүдийг тосолж, хатаж хуурайшихаас хамгаалдаг. Бүх дотоод эд анги нь үйлдвэрлэгчээс гаргасан хүлцэх утгад багтдаг тул дотоод даралт нь тэнцвэртэй байж нэвтрэх хурдыг нэмэгдүүлдэг.



Алхны эдэлгээг уртасгана – Туйлт чанар өндөр, тосолгооны чанар сайн байдгаас энэхүү өрмийн алхны тос доор цохилтот алхны эдэлгээг 75 хүртэлх хувиар уртасгах боломжтой. Өрмийн алхны тосны тослох чанар маш өндөр тул алхны гол болон бусад хөдөлгөөнт эд анги дээр хальсан бүрхүүл суурилуулдаг гэсэн үг. Ингэснээр төхөөрөмжийг ашиглаагүй үед элэгдэх, зэврэхээс хамгаалдаг.




Тохирол/нийцэл – Илүү байгальд ээлтэй. Байгальд ээлтэй өрмийн алхны тос нь хор хөнөөл багатай, байгаль орчны хууль тогтоомжуудад нийцдэг нь байгалийн нөөц баялаг цэцэрлэгт хүрээлэн, усны хагалбар газар зэрэг эмзэг хэсэгтэй ойролцоо оршдог уул уурхайн салбарт тун чухал юм.



BLACK DIAMOND ӨРМИЙН АЛХНЫ ТОСНЫ КЭЙС СУДАЛГАА

Сүүлд хийсэн туршилт судалгаанаас үзэхэд хоёр ижил өрмийн машин дээр хооронд нь харьцуулах боломжтой нөхцөлд өрөмдлөг хийхэд энэхүү өрмийн алхны тос нэвтрэлтийн хурдыг нэмэгдүүлдэг нь батлагдсан. Туршилтаар 5000 метрийн гүнд өрөмдлөг хийхэд байгальд ээлтэй өрмийн алхны тос бүх үзүүлэлтээр уламжлалт өрмийн алхны тосноос илүү үр дүнтэй гарсан.

Үзүүлэлт	Стандарт өрмийн алхны тос	Байгальд ээлтэй өрмийн алхны тос
Нийт өрөмдсөн метр	20,000	20,000
Нэг цагт өрөмдсөн метр	18	23
Нэг ээлжинд өрөмдсөн метр	144	184
Нийт ээлж (20,000 метр өрөмдлөг)	132	100
Нийт цаг (20,000 метр өрөмдлөг)	1080	800



● Био задралд орох чадвартай өрмийн алхны тос ● Уламжлалт өрмийн алхны тос

BLACK DIAMOND БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ӨРМИЙН АЛХНЫ ТОС

Black Diamond байгальд ээлтэй өрмийн алхны тос бол өмнө нь доор цохилтот алханд ашигладаг байсан уламжлалт газрын тосноос гаргаж авсан тосны оронд хэрэглэх байгальд ээлтэй шийдэл билээ. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр болон байгальд био задралд орох чадвартай нэгдлүүдээс гаргаж авсан учир тосолгооны чанар маш сайн, элэгдэл хорогдлоос сайтар хамгаалагдсан; зэвэнд идэгдэх, элэгдэх зэрэгт тэсвэртэй байдаг. Үүний үр дүнд төхөөрөмжийн гүйцэтгэл сайжирч, эдэлгээ уртасч, шингэн зарцуулалт багассан. Энэхүү байгальд ээлтэй өрмийн алхны тос нь хоргүй, био задралд ороход бэлэн байдаг учраас байгаль орчны зорилгоор ашиглахад нэн тохиромжтой байж, компаниудад өрөмдлөгийн үр дүнг бууруулахгүйгээр тогтвортой хөгжил болон байгаль орчны зорилтуудыг ханган ажиллахад тус дөхөм болдог.

Black Diamond байгальд ээлтэй өрмийн алхны тосыг төрөл бүрийн хэмжээтэйгээр бэлтгэн нийлүүлдэг. Үүнд:

Бэлэн нийлүүлэх хэмжээнүүд:



5L




PAIL – 20L



DRUM – 200L



IBC – 1000L



МӨН ИХ ХЭМЖЭЭГЭЭР
НИЙЛҮҮЛНЭ

БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ӨРМИЙН АЛХНЫ ТОСНЫ ХАРЬЦУУЛСАН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	Стандарт өрмийн алхны тос	Байгальд ээлтэй өрмийн алхны тос
ISO зэрэглэл	100	46
Цельсийн 40 хэм дэх зунгаг чанар	100	46
Цельсийн 100 хэм дэх зунгаг чанар	11.3	8.9
Цельсийн царцах хэм	-33	-35
Цельсийн ноцох хэм	230	280
Био задралд орох чанар	Байгальд задрахгүй үлдэх	99%-иас дээш